Ревматоид артриттай өвчтөний амьдралын чанарын үнэлгээг хийсэн байдал

М.Зулжаргал[1], Д.Зулгэрэл[2], Л.Мөнх-Эрдэнэ[3]

[1]Улсын Хоёрдугаар төв эмнэлэг,
[2]АШУҮИС, АУС, Ревматологийн тэнхим
[3]АШУҮИС, НЭМС, Эрүүл мэндийн бодлого удирдлагын тэнхим

Үндэслэл: Ревматоид артрит өвчин нь үеийг хоёр талдаа ижил байдлаар гэмтээдэг архаг, давшилтат явцтай холбогч эдийн аутоиммун өвчин юм. Иймээс энэ өвчин нь өвчтөний амьдралын чанар болон цаашид өвчин даамжирвал үйл ажиллагааны чадамжийг бууруулахаас гадна насжилтыг багасгадаг.

Зорилго: Ревматоид артрит өвчтэй өвчтөний амьдралын чанарын өөрийн үнэлгээг хийлгэж, өвчний үйл ажиллагааны ангилал тус бүрээр судлах

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгаанд нарийн мэргэжлийн ревматологийн эмнэлэгт 2019 оны 6-р сар болон 10-р сарын хугацаанд ирж үйлчлүүлсэн ревматоид артрит өвчнөөр оношлогдсон эсвэл анх удаа оношлогдож байгаа 120 өвчтөнийг аналитик судалгааны агшингийн загварыг ашиглан өвчтөний амьдралын чанарын өөрийн үнэлгээ хийх удирдамжийн дагуу судлав. Өвчтөний үйл ажиллагааны ангиллыг Америкийн Ревматологийн Коллежийн оношлогооны 1991 оны шинэчилсэн шалгууураар ангилсан. Судалгаанд дундаж, голч, стандарт хазайлт, давтамжийг статистик боловсруулалтын STATA 12 программыг ашиглан тооцсон.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт хүмүүсийн 102 (85%) өвчтөн нь эмэгтэйчүүд байсан. Дундаж нас нь 47.1±8.9 байв. РА-тай өвчтөнүүдийн 82(68%) нь ажилгүй байсан ба тэдгээрийн 54 нь хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмж авдаг байна. РА-ын үйл ажиллагааны ангиллаар үнэлвэл амьдралын чанар нь I үе шат-0.71 (n=24), II үе шат -1.15 (n=70), III үе шат-1.45 (n=21), IV үе шат-1.89 (n=5) тус тус байлаа. Үйл ажиллагааны ангиллын I үе шатанд болон II үе шатанд байгаа өвчтөнүүдийн амьдралын чанар тодорхой хэмжээгээр буурсан боловч эмчилгээний үр дүнд эргэн сэргэх боломжтой төлөвтэй байв. Харин III үе шатанд байгаа өвчтөнүүдийн амьдралын чанар ихээхэн буурсан, цаашид тухайн өвчтөнд нэмэлт асаргаа хэрэгтэй ба IV үе шатанд байгаа өвчтөнүүдийн амьдралын чанар алдагдсан, өвчтөн байнгын асран хамгаалагчийн хяналтанд байх шаардлагатай байна.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан нийт өвчтөний амьдралын чанарын дундаж нь дунд зэргийнх 1.15 (0.59) байлаа.
2. Ревматоид артритын үйл ажиллагааны ангилалын шатлал ихсэх тутамд өвчтнүүдийн амьдралын чанар буурч байлаа. Судалгаанд хамрагдсан өвчтөнүүдийн дийлэнхи нь үйл ажиллагааны II ангилалд хамаарагдаж байв.

Түлхүүр үг: Ревматоид артрит (РА), үйл ажиллагааны ангилал, амьдралын чанарын үнэлгээ

ЭРҮҮЛ

Quality of life self-assessment of patients with rheumatoid arthritis

Zuljargal M[1], Zulgerel D[2], Munkh-Erdene L[3]

[1]The 2nd Central Hospital
[2]School of Medicine, MNUMS
[3]School of Public Health, MNUMS

Introduction: Rheumatoid arthritis is a chronic, progressive and autoimmune disease which damaged the same joints on both sides of the body. Therefore, it has been negatively affecting patients' quality of life, physical function for long period of time, and life expectancy.
Purpose: To estimate self-assessed quality of life (QOL) of the rheumatoid arthritis (RA) patients, according to the classification of the functional activities.
Materials and methods: In this study was used a cross sectional study design to performed the QOL of 120 RA patients at the rheumatology private clinic in Ulaanbaatar, from June 1 to July 1 and from October 1 to November 1, 2019. For the evaluation of the quality of the life of RA patients we used guideline in self-assessed quality of life. The patients' functional activities status was assessed according to the revised criteria for the classification of functional activities of the RA patients by American College of Rheumatology in 1991 year. The mean, median, standard deviations, frequency of the findings were calculated using by a descriptive analysis of the STATA 12 program.
Result: In the study, majority of patients were women, as 102 patients (85%) and the mean age (SD) of study population was 47.1 (±8.9) years. The study was showed that the mainly of the RA patients 82 (68%) were unemployment and almost of half of the involved in this study RA patients (54) were under the disability pension. The self-assessed quality of life was estimated regarding to functional activities status, class I (n=24)-0.71, II (n=70)-1.15, III (n=21)-1.45 and IV (n=5)-1.89. Concluding previous result that the QOL of patients were "definitely worsened" in class I and II, nevertheless it will be recover based on the treatment. The QOL of patients was "need additional care" in class III and patients in class IV deteriorated, and they need permanent caregiver.
Conclusion:

1. Most of the RA patients had moderate self-assessed quality of life 1.15(0.59)
2. According to the worsening of the functional activities status the RA patients had less self-assessed quality of life. Majority of RA patients, who were involved in this study, had class II of functional activities status.

Keywords: Rheumatoid arthritis (RA), functional activities status, quality of life